

УРЬДЧИЛСАН ТАЙЛАН
2017 оны 5-р сарын 23-наас 6-р сарын -ний өдөр

2017 оны 6-р сарын 13

I. ТОВЧ ХУРААНГУЙ

- 2017 оны 1-р сарын 26-ны өдөр парламент (*Улсын Их Хурал*)-аас ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийг 6-р сарын 26-ны өдөр явуулахаар товлов. Ерөнхийлөгч нь улсын хэмжээнд сонгуулийн нэг тойргоос олонхийн буюу мажоритар тогтолцоо бүхий хоёр шаттай сонгуулиар шууд сонгох эрхийн үндсэн дээр сонгогдоно. УИХ-ын болон ерөнхийлөгчийн бүрэн эрхийг дахин хуваарилах талаар Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар яригдаж буй хэлэлцүүлэг нь энэ сонгуулийн нэг содон дүр зураг болж байна.
- Сонгуулийн тухай хууль тогтоомжоор суурь эрх, эрх чөлөөг хангасан байдаг. Гэвч ЕАБХАБ/АИХЭГ-аас өмнө нь өгсөн зарим санал зөвлөмжүүдийг анхааран авч үзсэн хэдий ч ялангуяа сонгох эрхтэй холбогдох зарим чухал зөвлөмжүүдийг орхигдуулсан байна.
- Сонгуулийн ерөнхий хороо (СЕХ) нь сонгуулийн бэлтгэл ажлыг сонгууль зохион байгуулах цаг хугацааны хуваарь болон хуульд заасан чухал хугацаануудад багтаан явуулж байна. Гэвч доод шатны сонгуулийн хороодод ажиллах ажилтнуудыг томилох үйл явц нь төрийн албан хаагчдаас сонгох сонгуулийн байгууллагын тогтолцооны дагуу байх ёстой ч намын харьяалал харгалзах явдал ажиглагдаж байна. Сонгуулийн хороодод ажиллах ажилтнуудад болон сонгогчдын боловсролд зориулсан сургалтууд явагдаж байна.
- Нийт 2,032,094 сонгогч сонгуульд оролцохоор бүртгэгдсэн. Сонгогчдын нэрийн жагсаалтыг 3-р сарын 1-ний өдрөөс эхлэн цахим хэлбэрээр байршуулсан бөгөөд санал авах байрууд болон орон нутгийн засаг захиргааны байгууллагууд дээр ерөнхийдөө 6-р сарын 6-ны өдрөөр эцэслэн олон нийтэд ил болгон танилцуулсан. 7,200 гаруй сонгогч гадаад улсад санал өгөхөөр бүртгэгджээ.
- 5-р сарын эхээр УИХ-д суудалтай гурван нам нэр дэвшигчдээ сонгох дотоод сонгон шалгаруулалтыг явуулсан ч энэ шалгуур нь тэр бүр сайтар тодорхойлж, ил тод болгосон шалгуурын дагуу явагдсангүй. СЕХ нь Ардчилсан нам (АН) болон Монгол ардын нам (МАН)-ыг төлөөлж буй нэр дэвшигчдийг бүртгэсэн ч Монгол ардын хувьсгалт нам (МАХН)-ын нэр дэвшигчийг сонгуульд нэр дэвшигчид тавигдах шаардлагыг хангаагүй гэж бүртгэхээс татгалзжээ. МАХН өөр нэр дэвшигчийг дэвшүүлснээр СЕХ бүртгэн авав.

- Сонгуулийн сурталчилгааны өмнөх байдал харьцангуй тайван байсан. Хэдийгээр хуулиар хориотой ч нэр дэвшигчид сонгуулийн сурталчилгаа албан ёсоор эхлэхээс өмнө сонгуулийн сурталчилгааны шинжтэй зарим үйл ажиллагааг явуулж байв. 6-р сарын 6-ны өдөр сонгуулийн сурталчилгаа эхэлж, нийслэл хот болон орон даяар олон тооны хурал цуглаан болов. Дайсагнасан, улс төрийн намын шинжтэй сэтгэгдлүүд нийгмийн сүлжээгээр давамгайлж байснаас гадна бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр төлбөртэй цацагдах явдал нийтлэг байлаа.
- Нэр дэвшигчдэд өрсөлдөх боломж, нөхцлийг ижил тэгш байлгахын тулд Үндэсний аудитын газар (ҮАГ) сонгуулийн сурталчилгааны зардлын хязгаарыг нэр дэвшүүлж буй намын хувьд 6.8 тэрбум төгрөг (2.5 сая евро), нэр дэвшигчийн хувьд 3.9 тэрбум төгрөг (1.5 сая евро) байхаар тогтоожээ. Гэвч нэр дэвшигчид зардлын тайлангаа ҮАГ-т сонгууль дууссаны дараа тайлагнахаас өөр шаардлагыг хуульд заагаагүй байна.
- Хэдийгээр зар сурталчилгааны зах зээл хязгаарлагдмал ч 450 гаруй хэвлэл мэдээллийн хэрэгсэл ажиллаж байна. Хэвлэл мэдээллийн байгууллагын өмчлөл бүрхэг, мэдээллийн агуулга нь улс төрийн харьяаллаар тодорхойлогдож байна. Олон нийтийн радио телевизээр төлбөргүй нэвтрүүлэх сурталчилгааны нэвтрүүлгийн цагийг бүх нэр дэвшигчид тэнцүү олгохыг шаардаж байгаа бол, доод тал нь хувийн хэвшлийн 156 мэдээллийн хэрэгсэл улс төрийн сурталчилгаанд зориулан нэвтрүүлгийн цаг, орон зайгаа худалдана. ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ нь 5-р сарын 29-ний өдөр өөрийн хэвлэл мэдээллийн хяналт шинжилгээ (мониторинг)-г эхлүүлэв.
- Иргэн, хуулийн этгээд нь сонгуулийн үйл явцад хамаарах аливаа шийдвэр, үйл ажиллагааны талаар өргөдөл гомдол гаргах эрхтэй байдаг. Маргааныг шийдвэрлэх эцсийн хугацаа нь сонгууль дууссан хойно хүртэл сунжрахад хүргэж байв. ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ-нд мэдээлснээр одоогийн байдлаар сонгуулийн хороод, эсвэл холбогдох шүүх дээр гурван өргөдөл гаргаад байна. Нэг өргөдөл нь нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзсантай холбоотой бол, хоёр нь доод шатны сонгуулийн хороодын бүрэлдэхүүний талаар гомдол гаргажээ.
- Хууль эрх зүйн хүрээ нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төрд оролцох эрхийг хүлээн зөвшөөрч, улс төрийн намуудад сурталчилгааны материалаа тэдэнд хүртээмжтэй болгох үүргийг хүлээлгэдэг. СЕХ нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн санал өгөх эрхийг хөнгөвчлөх, мэдээллээр хангах хэд хэдэн арга хэмжээг авч байна.
- Иргэний нийгмийн байгууллагууд нь сонгуулийн өмнөх орчинг ажиглах тал дээр идэвхтэй ажиллаж байна. Иргэд олон нийтийн ажиглагчид хэвлэл мэдээлэл, сонгуулийн сурталчилгааны зардал, санал тоолох автомат төхөөрөмжийн бэлтгэл ажил зэрэгт мониторинг хийж байгаагаас гадна сонгуулийн өдрийг дөхүүлэн уг төхөөрөмж дээр нэмэлт, бие даасан шалгалтыг хийнэ.

II. ОРШИЛ

2017 оны 1-р сарын 26-ны өдөр парламент (*Улсын Их Хурал*)-аас ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийг 6-р сарын 26-ны өдөр явуулахаар товлон. Монгол Улсын Гадаад харилцааны яамны урилгын дагуу, мөн 2017 оны 2-р сарын 21-нээс 24-ний хооронд хийсэн Урьдчилсан судалгааны тайланд тусгагдсан зөвлөмжүүд дээр үндэслэн ЕАБХАБ-ын Ардчилсан институт хүний эрхийн газар (ЕАБХАБ/АИХЭГ)-аас Сонгууль ажиглах хязгаарлагдмал хүрээ бүхий хороо (САХХ)-г 5-р сарын 22-ны өдөр байгуулав.¹ ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ-ны тэргүүнээр Элчин сайд Гээрт-Хинрич Арэнс (Герман) ажиллаж байгаа бөгөөд 11 хүний бүрэлдэхүүнтэй үндсэн баг Улаанбаатар хотод байрлаж, 20 урт хугацааны ажиглагч Монгол Улс даяар байршин ажиллаж байна. Хорооны гишүүдийг ЕАБХАБ-ын гишүүн 20 улсаас бүрдүүлсэн. ЕАБХАБ-ын АИХЭГ-ын сонгуулийн ажиглалт хийх аргачлалын дагуу тус хороо нь сонгуулийн өдрийн үйл явцад нэг бүрчлэн, дэлгэрэнгүй ажиглалт хийхээр төлөвлөөгүй боловч сонгуулийн өдөр тодорхой тооны хэсгийн хороод дээр очиж, ажиглалт хийхээр зорьж байна.

III. УЛС ТӨРИЙН ОРЧИН

Монгол Улс нь холимог буюу хагас ерөнхийлөгчийн засаглалтай бүгд найрамдах улс бөгөөд ерөнхийлөгч болон УИХ нь өргөн хүрээтэй, зарим тохиодолд хоорондоо давхардсан эрх мэдэлтэй байдаг. УИХ болон ерөнхийлөгчийн бүрэн эрхийг дахин хуваарилах талаар Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар олон нийт ба парламент дээр яригдаж буй хэлэлцүүлэг нь энэ сонгуулийн нэг содон дүр зураг болж байна.

Ерөнхийлөгчийн сонгууль нь 2016 оны 6-р сарын 29-ний өдөр болсон УИХ-ын сонгууль болон 2016 оны 6, 10-р сард тус тус болсон орон нутгийн хурлын сонгуулийн дараа болж байна. Энэхүү сонгуулийн мөчлөгөөр Монгол ардын нам (МАН) парламентын 76-н суудлын 65-ыг авч улс төрийн давамгайл байддалд очсон төдийгүй ихэнх аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлуудад олонх болсон. Засгийн газрын бүх гишүүн, мөн 21 аймгийн нэгээс бусад бүх засаг дарга нь МАН-ын харьяалалтай. Ардчилсан нам (АН) УИХ-д 9 суудал авсан бөгөөд энэ нь тус намд намын бүлэг байгуулах боломжийг бүрдүүлсэн бол, Монгол ардын хувьсгалт нам (МАХН) нэг суудалтай.

Энэ удаагийн сонгууль нь эдийн засгийн хямрал үргэлжилж, дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт доройтон, гадаадын шууд хөрөнгө оруулалт буурч, ажилгүйдэл ихэссэн нөхцөлд явагдаж байна. Хоёрдугаар сард Монгол Улс нь Олон улсын валютын сан болон бусад зээлдүүлэгчдээс тусламж авах гэрээг байгуулсан ба ингэснээр шууд төлбөрийн чадваргүй болох эрсдлээ бууруулж, засгийн газар нийгмийн хамгааллын гол хөтөлбөрүүдээ үргэлжлүүлэх боломжтой болсон билээ. Эдийн засгийн хоосрол, Монгол Улсын эдийн засгийн өсөлт улам бүр БНХАУ-аас хамааралтай болж байгаа зэрэг нь популист болон гадаадынхны эсрэг үзэл санааг цагтаж, сонгуулиас өмнө тогтворгүй орчин нөхцөл үүсэхэд нөлөөлж байна.

¹ ЕАБХАБ/АИХЭГ-аас Монгол Улсын талаар гаргасан өмнөх бүх тайланг үзнэ үү.

IV. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН БА СОНГУУЛИЙН СИСТЕМ

Монгол Улс нь олон улсын хүний эрхийн чухал гэрээ конвенциудад нэгдэн орсон. Ерөнхийлөгчийн сонгуулийн хууль эрх зүйн хүрээ нь 1992 оны Үндсэн хууль (хамгийн сүүлд 2011 онд нэмэлт өөрчлөлт орсон), 2016 онд нэмэлт өөрчлөлт оруулсан 2015 оны Сонгуулийн тухай хууль (СТХ), 2006 оны Сонгуулийн төв байгууллагын тухай хууль (СТБТХ), 2011 оны Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль (САСТХ) болон 2005 оны Улс төрийн намын тухай хууль (УТНТХ) зэргээс бүрдэж байна.² Эдгээр үндсэн хууль тогтоомж дээр Сонгуулийн ерөнхий хороо (СЕХ)-ноос гаргаж буй дүрэм журмууд мөн дагалдаж байна. Гэвч СТХ болон СТБТХ-иар хуулийн заалтуудыг хөрвүүлэх, мөн сонгуулийн тухай үндсэн хууль тогтоомж дээр нэмж шаардлагатай гэж үзсэн зохицуулалтыг батлах СЕХ-ны бүрэн эрхийг хязгаарлагдмал хүрээнд хангаж өгсөн байдаг. Гэсэн хэдий ч СЕХ нь Дээд шүүхэд хандан сонгуулийн хууль тогтоомжийн талаар албан ёсны тайлбар өгөхийг шаардаж болно. 2012 оноос хойш Дээд шүүх нь үндсэн хуулиар олгогдсон энэхүү бүрэн эрхээ хэрэгжүүлж чадахгүй байгаагийн улмаас сонгуульд зориулсан уялдаа холбоо бүхий цогц хууль эрх зүйн хүрээг боловсронгуй болгох арга хэрэгслийг хязгаарлаж байгаа юм.³

Энэ удаагийн сонгууль нь сонгуулийн тухай хэд хэдэн хуулийг нэгтгэсэн СТХ-иар явагдаж буй анхны ерөнхийлөгчийн сонгууль юм. СТХ-нд сүүлийн УИХ-ын сонгуулийн өмнөхөн батлагдсанаасаа хойш хоёр удаа (2016 оны 2 ба 5-р сард) нэмэлт өөрчлөлт оруулсан. ЕАБХАБ/АИХЭГ-аас өмнө нь өгсөн зарим зөвлөмжүүдийг хүлээн авсан байна. Тухайлбал нэр төр гутаасан хэргийг эрүүгийн хэрэгт тооцохгүй болгосон, мөн сонгуулийн хороодын болон шүүхийн маргаан шийдвэрлэхтэй холбоотой журам, заалтууд ямар нэг хэмжээгээр тодорхой болсон байна. Гэвч бусад зөвлөмжүүд, ялангуяа сонгох эрхийг хязгаарласантай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг орхигдуулсан байна.

Ерөнхийлөгч нь улсын хэмжээнд сонгуулийн нэг тойргоос олонхийн буюу мажоритар тогтолцоо бүхий хоёр шаттай сонгуулиар шууд сонгох эрхийн үндсэн дээр сонгогдоно. Хэрэв улсын хэмжээнд сонгуулийн ирц 50 хувиас доош гарвал ирц нь энэ босгоос доош байсан сонгуулийн хэсгүүд дээр нэг долоо хоногийн дотор дахин санал авна. Дахин санал хураахад зөвхөн сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн боловч сонгуулийн өдөр саналаа өгөөгүй сонгогчид санал өгнө. Дахин санал хураалтаар өгсөн саналын тоог анхны санал хураалтын тоон дээр нэмэх бөгөөд дахин санал хураалт хийгдэхгүй. Хэрэв нэр дэвшигчдийн хэн нь ч олонхийн санал аваагүй бол олонхийн санал авсан хоёр нэр дэвшигчийн дунд анхны санал хураалт авсан өдрөөс хоёр долоо хоногийн дотор дахин сонгууль явуулна.

V. СОНГУУЛИЙН БАЙГУУЛЛАГА

СЕХ нь ерөнхийлөгчийн сонгуулийг зохион байгуулах талаар өргөн хүрээтэй үүрэг хариуцлагыг хүлээж байгаа бөгөөд одоогийн байдлаар ээлжит сонгуулийг зохион байгуулах цаг хугацааны хуваарь болон хуульд заасан чухал хугацаануудад багтаан олон тооны үүрэг

² Мөн Эрүүгийн хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиудын холбогдох заалтууд хамаарна.

³ 2012-2015 онд СЕХ нь Дээд шүүхэд хандан сонгуулийн хуулийн заалтуудын талаар албан ёсны тайлбар авахаар хэд хэдэн хүсэлтийг хүргүүлсэн боловч ямар нэг хариу аваагүй тул дахин хүсэлт илгээхээ зогсоожээ.

даалгавруудыг хийж гүйцэтгэж байна.⁴ Сонгуулийн үндсэн хууль эрх зүйн орчныг сайжруулахад СЕХ-ны эрх хэмжээ хязгаарлагдмал байгаа нь сонгуулийг зохион байгуулах СЕХ-ны зарим үйл ажиллагаанд саад учруулж болох юм.

СЕХ нь байнгын ажиллагаатай төрийн байгууллага бөгөөд есөн гишүүний бүрэлдэхүүнтэйгээс нэг гишүүн нь эмэгтэй, УИХ (5 гишүүн), Монгол Улсын ерөнхийлөгч болон Улсын дээд шүүх (тус бүр 2 гишүүн)-ээс санал болгосноор зургаан жилийн хугацаатайгаар томилдог. 2017 оны 4-р сарын 12-нд СЕХ нь 22 АНСХ-ны 188 гишүүнийг томилсон бөгөөд хорооны гишүүдийн 97 буюу (50 гаруйхан хувь) нь эмэгтэйчүүд байна.⁵ 4-р сарын 22-нд АНСХ нь 339 Сум дүүргийн сонгуулийн хороо (СДСХ)-ны бүрэлдэхүүнийг томилсон бөгөөд эдгээр хороод нь 1983 сонгуулийн хэсгийн хороо (СХХ)-ны бүх гишүүнийг томилно. СХХ-дын ихэнх дарга нарыг 5-р сарын 27-ноор эцэслэн томилсон байна. СХХ-ны бусад гишүүдийг 6-р сарын 19-ний өдрөөс хэтрэлгүй томилох ёстой боловч зарим АНСХ болон СДСХ-д энэхүү томилгооны үйл явц аль хэдийн дууссан гэдгийг мэдээлжээ.

АНСХ, СДСХ, СХХ-дын ажилтнуудыг СЕХ-оос итгэмжлэгдсэн 23,000 гаруй төрийн албан хаагчдын жагсаалтаас сонгон томилогдох ёстой. Аль ч шатны сонгуулийн хороодын ажилтнуудыг сонгон шалгаруулах нэгдсэн дүрэм журам байхгүй боловч өмнөх туршлагыг гол шалгуур болгож байгаа гэж дурдав. Гэвч доод шатны сонгуулийн хороодод орон нутгийн засаг даргын тамгын газрын болон иргэдийн хурлын удирдах албан тушаалтнуудыг томилсон явдал нь төрийн албан хаагчдаас сонгох ёстой сонгуулийн байгууллагын тогтолцоонд намын харьяалалыг харгалзсан явдал болж байна. Сонгуулийн хороодод ажиллах ажилтнуудад болон сонгогчдын боловсролд зориулсан сургалтууд явагдаж байна. 22 АНСХ-ны 21-ийг нь аймгийн ЗДТГ-ын дарга (8), ЗДТГ-ын хэлтсийн дарга (9), аймгийн ИТХТ-ийн нарийн бичгийн дарга (4) нар даргалж байна. Хороодын шийдвэр гаргах явцад улс төржих хандлага байгаа гэсэн хардлагыг ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ-ны уулзаж, ярилцсан хүмүүс илэрхийлж байв.

СЕХ нь гадаад улсад байгаа иргэдийн санал авах ажлыг удирдан зохион байгуулах долоон хүний бүрэлдэхүүнтэй Төв комиссыг байгуулсан. Тус комисс нь Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газар байрладаг 32 улсад байгуулсан 45 салбар комиссын сонгуулийн санал авах ажиллагааг 6 дугаар сарын 11-12-ны өдөр зохион байгуулав. Энэхүү санал тоолох ажиллагааг СЕХ сонгуулийн өдөр санал хураалт дууссаны дараа явуулна.

СТХ болон СЕХ-ны дүрэм журамд бүх шатны сонгуулийн хороод холбогдох асуудлуудаа нийт бүрэлдэхүүний гуравны хоёроос доошгүй ирцтэй хэлэлцэж, хуралдаанд оролцсон гишүүдийнхээ олонхийн саналаар шийдвэрлэхийг заасан байдаг. Хуулиар сонгуулийн хороодын хуралдаан нь нээлттэй ил тод байж, хурлын тэмдэглэл хөтлөгдсөн байх шаардлагатай. Хуралдаанаар хэлэлцсэн асуудал болон шийдвэрийг сонгуулийн хороодын мэдээллийн самбарт байрлуулсан байх ёстой. Бүх шатны сонгуулийн хороодод

⁴ СЕХ нь сонгууль зохион байгуулахаас гадна сонгууль зохион байгуулах зардлыг хянах, Аймаг нийслэлийн сонгуулийн хороо (АНСХ)-дыг аймгуудад болон нийслэлд зохион байгуулах, нэр дэвшигчийг бүртгэх, сонгуулийн сурталчилгааны зардлыг хянах, сонгууль зохион байгуулах үйл явц, үйл ажиллагаатай холбогдуулан гарсан өргөдлийг шийдвэрлэх, сонгуулийн дүн гаргах зэрэг үүрэгтэй болно.

⁵ Сум, дүүргийн сонгуулийн хорооны бүрэлдэхүүний хүйсийн харьцааны задаргаа одоогоор гараагүй байгаа боловч ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ-ны ажиглагчдын зочилсон хороод дээр бүрэлдэхүүний хүйсийн харьцаа ойролцоо байв.

ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ-г дэмжин ажиллахыг мэдэгдсэн байна. Гэвч ихэнхдээ сонгуулийн хороодын хуралдааныг хэлэлцэх асуудал, хуваарийг олон нийтэд мэдээлэлгүй, *урьдчилж төлөвлөлгүй* хийж байна. ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ албан ёсоор нээгдснээс хойш СЕХ нэг удаа хуралдаж, гадаад улсад санал өгөх иргэдийн тоог мэдээлэх, саналын хуудасны загварыг батлах, олон нийтийн радио, телевизээр төлбөргүй нэвтрүүлэх сурталчилгааны нэвтрүүлгийн хуваарь, цагийг тогтоох зэрэг асуудлыг хэлэлцэж баталсан. СЕХ-ны цахим хуудас дээр сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийн хуваарь болон шийдвэрийг ил байрлуулж, олон нийтэд мэдээлэв.

СЕХ нь иргэдийн сонгох эрх, сонгуульд санал өгөх үйл явц болон ардчиллын ач холбогдол зэргийг тайлбарласан сонгогчийн боловсролд зориулсан гарын авлагыг боловсруулан, орон нутгийн засаг захиргааны байгууллагуудад байрлаж буй иргэний танхимуудад хүргүүлсэн. Мөн СЕХ нь сонгогчдод зориулан санал авах зааврыг бэлтгэж, иргэний танхимууд болон өөрийн цахим хуудаст байрлуулан, олон нийтэд мэдээлэл өгөх, сонгуульд идэвхтэй оролцохыг уриалсан кампанит ажлыг хийхээр төлөвлөж байгаа тухай мэдээлсэн. АНСХ-д нь сонгогчийн боловсролд зарцуулах төсөвтэй бөгөөд үүнд орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэвтрүүлэг цацах зардал багтдаг байна.⁶ Сонгогчийн боловсролд зориулсан материалуудыг улсын хэмжээнд буй ихэнх АНСХ болон СДСХ-дын гадна байрлуулсан байхыг ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ ажиглав.

СЕХ-ноос Улаанбаатар хот болон ихэнх АНСХ-нд буй бүх шатны сонгуулийн хороодын ажилтнуудад сургалт зохион байгуулсан. Нийслэл хотоос гадна буй доод шатны сонгуулийн хороодын ажилтнуудад зориулсан сургалтыг тухайн АНСХ, СДСХ-д нь зохион байгуулж байна.

Энэ удаагийн сонгууль нь Монгол Улсын хувьд сонгуулийн автоматжуулсан систем хэрэглэн явуулж буй зургаа дах сонгууль юм. Санал тоолох төхөөрөмж дээр байрлах оптик сканнер нь саналын хуудасны дугаарыг санан хадгалж, санал хураалтын дүнг нэгтгэж, хэвлээд улмаар санал авах ажиллагаа дуусмагц бүх саналыг тоолон дүнг СЕХ-нд дамжуулна. СЕХ нь сонгуулийн урьдчилсан дүнг аймаг тус бүрээр, нийслэл хотын хувьд дүүрэг тус бүрээр нь жагсаан, өөрийн цахим хуудсанд сонгуулийн шөнө мэдээлэхээр төлөвлөж байна.

VI. СОНГОГЧИЙН БҮРТГЭЛ

Эрх зүйн чадамжгүй, гэмт хэргийн ангиллаас үл хамааран хорих ял эдэлж буй бүх этгээдээс бусад 18 насанд хүрсэн, эрх зүйн бүрэн чадамжтай иргэн санал өгөх эрхтэй.

Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар (ОӨУБЕГ) нь сонгогчийн нэрийн жагсаалтыг эрхлэн үйлдэж, танилцуулах үүрэгтэй. 3-р сарын 1-нээс эхлэн сонгогчид нь сонгогчийн нэрсийн жагсалтад бүртгэгдсэн эсэхээ болон санал өгөхтэй холбогдох мэдээллээ ОӨУБЕГ-ын цахим хуудаст нэвтэрч шалгах боломжтой. Иргэдээс гаргасан хүсэлт болон төрийн байгууллагуудаас оруулсан саналыг үндэслэн холбогдох өөрчлөлтүүдийг тусгасан

⁶ СЕХ нь сурталчилгааны материал, нэвтрүүлгийг бэлтгэн АНСХ-дод хүргүүлдэг учир орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацах зардлыг сонгуулийн хорооны төсвөөс гаргадаг.

сонгогчдын нэрсийн жагсаалтыг 5-р сарын 31-ний өдөр буюу хуулинд заасан хугацаанд багтаан гаргав. Энэхүү шинэчлэгдсэн сонгогчдын нэрийн жагсаалтад нийт 2,032,094 сонгогч бүртгэгдсэн байна. Үүнээс “түр хасав” тэмдэглэгээтэй 44,833, Монгол Улсаас гадаад улсад санал өгөхөөр 7,209 сонгогч тус тус бүртгэгдсэн байна.⁷ Зэвсэгт хүчний анги, нэгтгэлд алба хааж байгаа сонгогчид нь алба хааж буй газрууддаа саналаа өгөхөөр бүртгэгджээ.

ОӨУБЕГ нь 5-р сарын 31-ний дотор сонгогчдын нэрийн жагсаалтыг бүх АНСХ болон Улаанбаатар хотын есөн СДСХ-нд хүргүүлсэн бөгөөд эдгээр хороод нь уг жагсаалтыг холбогдох хэсгийн хорооддоо 6-р сарын 6-ны өдрөөр эцэслэн хүргүүлэв. Сонгогчдын нэрийн жагсаалтыг санал авах байрууд болон орон нутгийн засаг захиргааны байруудад олон нийтэд ил байрлуулсан боловч жагсаалтыг хүлээн авсан даруйдаа тавих ёстой гэсэн хуулийн заалтыг тэр бүр мөрдсөнгүй. Иргэд сонгогчдын нэрийн жагсаалттай холбоотой гарсан алдаа, орхигдуулсан мэдээллийг 6-р сарын 11-ний дотор өргөдлөөр гаргах боломжтой. Сонгогч хувийн мэдээллээ биеэр очин шалган баталгаажуулах хугацаа богино тул сонгогчдийн нэрийн жагсаалтыг ийнхүү хугацаанд нь ил тавихгүй байх явдал нь сонгогчдод холбогдох өөрчлөлтөө оруулахад нь нөлөөлөх магадлалтай юм.

Мөн 6-р сарын 11-ний дотор багтаан сонгогч нь өөрийн биеэр, эсвэл итгэмжлэлээр өөрийн байнга оршин суугаа газрын харьяа сонгуулийн хэсгээс өөр аймаг руу шилжих хүсэлт гаргах эрхтэй. Сонгуулийн өдөр ажиллахаар үүрэг хүлээсэн сонгуулийн хороодын ажилтнууд, цагдаа, иргэний бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн төлөөлөгчид болон мэдээлэл, технологийн ажилтнууд нь 6-р сарын 25-ны өдөр явуулын битүүмжилсэн хайрцгаар саналаа өгөх боломжтой. Эдгээр хүмүүс нь өөрийн харьяа сонгуулийн хэсгээс хол газар очиж ажилах тохиолдолд саналаа өгөх боломж нь хязгаарлагдах бодит нөхцөл байдал үүсэж болох юм.⁸ Санал авах өдөр хэсгийн хороодод ажиллаж буй иргэний бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтан саналаа өгөхөөр ирсэн сонгогчийн хурууны хээг шалгаж, сонгогчдын нэрсийн жагсаалттай тулгаж үзнэ.

VII. НЭР ДЭВШИГЧИЙН БҮРТГЭЛ

УИХ-д суудалтай гурван намаас дэвшүүлсэн гурван хүнийг сонгуульд нэр дэвшигчээр бүртгэв. Бусад нам нэр дэвшүүлэх эрхгүй бөгөөд бие даан нэр дэвшихийг зөвшөөрдөггүй. Түүнчлэн эрх бүхий нэр дэвшигч нь 45 нас хүрсэн, Монгол Улсын харьяат эцэг эхээс төрж, сүүлийн таваас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан байх ёстой. Нэр дэвшигч нь зээл, барьцаа, хугацаа хэтэрсэн албан татварын өр төлбөр, эсвэл эрүүгийн гэмт хэргийн бүртгэлгүй байх шаардлагатай. Нэр дэвшигчид тавигдах шаардлагууд хэтэрхий хязгаарлагдмал, тэр дундаа бие даан нэр дэвших талаар хуулийн заалт байхгүй, албан татварын хугацаа хэтэрсэн өртэй болон зээлийн өртэй нэр дэвшигчдийг хасаж байгаа талаар ЕАБХАБ/АИХЭГ-аас өмнө нь шүүмжилж байсан.

2017 оны 5-р сарын эхээр нэр дэвшүүлэх үйл ажиллагаа эхлэхээс 5 хоногийн өмнө УИХ-д

⁷ СТХ-д зааснаар эрх зүйн чадамжгүй, хорих газар ял эдэлж байгаа болон 60 ба түүнээс дээш хоногийн хугацаагаар гадаад улсад зорчсон сонгогчийг сонгогчдын нэрийн жагсаалтад “түр хасав” гэж тэмдэглэнэ.

⁸ СЕХ нь АНСХ, СДСХ-дод СХХ-дын ажилтнуудыг оршин суугаа газрын харьяа, эсвэл ойрхон сонгуулийн хэсэгт томилон ажилуулахыг зөвлөсөн.

суудалтай улс төрийн гурван нам бүгд нэр дэвшигчээ шалгаруулах дотоод сонгон шалгаруулалтыг хийсэн боловч тэр бүр сайтар тодорхойлсон, ил тод шалгуурын дагуу явагдаагүй. АН улсын хэмжээнд, зургаан нэр дэвшигчийг оролцуулсан хаалттай сонгуулийг зохион байгуулсан бөгөөд 5-р сарын 6-нд болсон үндэсний чуулганаараа сонголтоо албан ёсоор баталгаажуулсан. МАН нэр дэвшигчээ 5-р сарын 3-ны өдөр намын бага хурлаа хийн, хоёр боломжит нэр дэвшигчийн дундаас сонгон тодруулсан бол, МАХН намын даргаа нэр дэвшүүлжээ. Улмаар улс төрийн намууд нэр дэвшигчдийн материалаа нягтлан шалгуулахаар СЕХ-нд албан ёсоор хүргүүлэв. СЕХ нь АН-ын болон МАН-ын нэр дэвшигчдийг бүртгэж, харин МАХН-аас нэр дэвшигчийг нэр дэвшихээс өмнөх хугацаанд Монгол Улсад байнга оршин суугаагүй, мөн 2012 оноос эхэлсэн ялтайд тооцох хугацаа нь дуусаагүй гэх үндэслэлээр нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзжээ.⁹ МАХН энэ шийдвэрийг давж заалдахаар Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргасны зэрэгцээ хуульд заасан хугацаанд багтаан өөр нэр дэвшигчийг нөхөн дэвшүүлсэн ба СЕХ уг нэр дэвшигчийг 5-р сарын 17-ны өдөр албан ёсоор бүртгэж авав. СЕХ нь 5-р сарын 27-ны өдөр нэр дэвшигчээр бүртгэгдсэн гурван нэр дэвшигчид нэр дэвшигчийн үнэмлэхийг нь олгов. Ерөнхийлөгчийн сонгуульд дэвшиж буй нэр дэвшигчид бүгд эрэгтэй.

VIII. СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААНЫ ОРЧИН

Нэр дэвшигчид сонгуулийн сурталчилгаагаа 6-р сарын 6-ны өдөр эхэлсэн бөгөөд сурталчилгааг санал авах өдрөөс 24 цагийн өмнө дуусгана. СТХ-иар сонгуулийн сурталчилгааг зохион байгуулж явуулахтай холбогдсон бүхий л харилцааг нарийвчлан зохицуулж өгсөн. Орон нутгийн засаг захиргааны болон сонгуулийн байгууллага нь гадаа сурталчилгааны зурагт самбар байрлуулах газруудыг хуваарилах, мөн нэр дэвшигчдийн сонгуулийн штабын ажилтнуудыг болон сонгуулийн сурталчилгаанд ашиглах тээврийн хэрэгслүүдийг бүртгэх зэргээр сонгуулийн сурталчилгааг зохицуулахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Ээлжит сонгуулийн жил эхэлснээс хойш сурталчилгааны зорилгоор бэлэн мөнгө, эд зүйл тараах болон амлах, үйлчилгээ үзүүлэх, хувьцаа өгөх, ажилд зуучлах, нийтийг хамарсан тэмцээн, баяр наадам, урлагийн тоглолт зэргийг зохион байгуулах, ивээн тэтгэх хориотой. Нэр дэвшигчдийн ажлын ололт амжилтыг сурталчлах нь сонгуулийн сурталчилгаанд тооцогдохгүй учраас сурталчилгааны хориг хязгаарт хамаарахгүй байна.

Нэр дэвшигчдийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг Үндэсний аудитын газар (ҮАГ)-аас санхүүгийн эх үүсвэрийн талаарх тооцоо, судалгаа болон Монгол Улсын эдийн засаг, хөгжлийн бодлогод нийцэж байгаа эсэхээр шалган, урьдчилан батлах ёстой байгаа нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, улс төрийн олон ургалч үзлийг шаардлагагүйгээр хязгаарлаж буй явдал юм. 5-р сарын эхээр ерөнхийлөгчийн сонгуульд оролцож буй гурван нам мөрийн хөтөлбөрөө ҮАГ-т өгчээ. Намуудын мөрийн хөтөлбөрт нийт 208 зорилт тусгагдснаас 41 зорилтыг нь ҮАГ зохих засвар өөрчлөлтүүдийг хийх шаардлагатай гэж үзжээ.¹⁰ Намууд зохих засвар өөрчлөлтүүд оруулж, мөн зарим нэг зорилтуудыг нь хассан мөрийн хөтөлбөрийг 5-р сарын 10-ны өдөр ҮАГ-т дахин хүргүүлжээ. Эхний удаад дэвшүүлсэн нэр дэвшигчийг нь

⁹ Эрүүгийн хуульд зааснаар ялтайд тооцогдох хугацаа нь ял эдэлж дуусснаас хойш тодорхой хугацаа өнгөрсний дараа хүчингүй болно.

¹⁰ Тодруулбал, 12 зорилт нь МУ-ын хөгжлийн үзэл баримтлалд нийцээгүй, 13 зорилт санхүүгийн тооцоолол хангалтгүй, 17 зорилт Үндсэн Хуульд заасан Ерөнхийлөгчийн бүрэн эрхтэй нийцээгүй байна.

бүртгэж авахаас татгалзсан учир МАХН мөрийн хөтөлбөрөө дахин хүргүүлэх шаардлагатай болсон боловч ирүүлсэн мөрийн хөтөлбөрийг нь ямар нэг өөрчлөлтгүйгээр шууд баталсан.

Сонгуулийн сурталчилгааны өмнөх байдал харьцангуй тайван байлаа. Харин гурван нэр дэвшигчийн хувьд гурвуулаа сонгуулийн сурталчилгааг эрт эхлүүлсэн явдал ажиглагдсан боловч цаг хугацааны хувьд янз бүр байлаа. МАН болон АН-ын нэр дэвшигчид нэр дэвшигчийн үнэмлэхээ гардан авсныхаа дараа 5-р сарын 27-ны өдөр томоохон цуглаан зохион байгуулсан. Энэ цуглаануудын үеэр нэр дэвшигчид болон тэдний дэмжигчид үг хэлж, гудамжинд жагсаал хийсэн. МАХН-аас нэр дэвшигч Улаанбаатар хотын захууд дээр олон нийттэй хэд хэдэн удаа уулзсан. ЕАБХАБ-ын АИХЭГ-ын САХХ-ны ажиглагчид Ховд аймагт зохион байгуулсан АН-ын цуглаан болон Улаанбаатар хотод МАН-ын ивээн тэтгэсэн концерт зэрэг дээр сонгуулийн сурталчилгааны шинжтэй бусад үйл ажиллагаа явагдсаныг онцолсон байна.

Хэвлэл мэдээллээр улс төрийн намуудын төлбөртэй болон редакцийн агуулга бүхий нэвтрүүлгүүд аль аль нь гарч байв. Түүнчлэн авилга, гадны ашиг сонирхолтой хуйвалдсан гэх нотлогдоогүй хардлагууд, мөн гадныхныг үзэн ядах, арьс өнгөөр ялгаварласан хэл яриа, хэт туйлшрал болон хүчирхийлэлд өдөөн турхирсан агуулгууд цацагдаж байсныг ЕАБХАБ-ын АИХЭГ-ын САХХ-ны зүгээс тэмдэглэв¹¹.

МАН-ын нэр дэвшигч нь эдийн засгийн нөхцөл байдлыг сайжруулж буй өөрийн намын амжилтуудыг онцлох байдлаар нийгэм, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах тухай мөрийн хөтөлбөрөөр сурталчилгаагаа явуулж байна. Харин АН болон МАХН-ын нэр дэвшигчид авилгатай холбоотой асуудлууд, мөн ядуурал, гадны ашиг сонирхолд үйлчлэх, уул уурхайн орлогын шударга бус хуварилалт зэрэг асуудлууд дээр төвлөрч байна. Түүнчлэн МАХН-ын нэр дэвшигчийн зүгээс АН болон МАН-ыг хоорондоо хуйвалдсан гэж сэжиглэж байна. АН, МАН-ын нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөр 6-р сарын 6-ны өдөр сонгуулийн сурталчилгаа эхэлсэн өдөртэй давхцан нийтлэгдэв. ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ-ны ажигласнаар МАН болон МАХН-ын нэр дэвшигчид сурталчилгаагаа эхлэхдээ Улаанбаатар хотод олон хүн оролцсон цуглаанууд дээр өөрийн биеэр оролцсон бол, АН-ын нэр дэвшигч өөрийн сурталчилгааг Хэнтий аймагт олон нийтийг хамарсан хэд хэдэн үйл ажиллагаа зохион байгуулснаар эхлүүлэв. МАН-аас улсын хэмжээнд зохион байгуулж буй сонгуулийн сурталчилгааны хурал уулзалтууд дээр ойролцоогоор 150-аас 1,000 орчим хүн оролцож байснаас гадна ерөнхийдөө өртөг зардал ихтэй, зохион байгуулалт өндөртэй болж байлаа. ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ-ны гишүүдтэй уулзаж ярилцсан олон хүн орон нутгийн засаг захиргааны байгууллагууд болон улс төрийн намын сурталчилгааны хоорондох зааг ялгаа ялгагдахгүй олон тохиолдол гарч байгаад санаа зовниж буйгаа ярьж байлаа.¹²

¹¹ Тухайлбал, “Улаан Тарианы Хүүхдүүд” гэсэн баримтат кинонд нэр нь дурдагдаагүй авлигын хэрэгт холбоотой албан тушаалтнуудыг хууль бусаар алахыг уриалсан агуулгатай байв. Уг баримтат кино нь нэр дэвшигчдийн нэгэнтэй нь холбоотой гэдэг нь олонд мэдэгдсэн нэгэн компанийн хийсэн кино бөгөөд 5-р сарын 29-ний өдөр нийт 5 телевизийн оргил цагийн нэвтрүүлгээр цацагдсан. Цаашилбал 5-р сарын 31-ний өдөр хоёр телевизээр ерөнхийлөгчид дэвшиж буй хоёр нэр дэвшигчийг хангалттай боловсролгүй гэж онцолсон нэгэн нэвтрүүлгийг цацжээ. Мөн арьс өнгөөр ялгаварлан гадуурхсан өнгө аястай тохиолдлууд сонгуулийн сурталчилгааны яриа илтгэлүүдийн үеэр гарч байсан нь ЕАБХАБ-ын АИХЭГ-ын САХХ-нд ажиглагдсан.

¹² Жишээ нь, Архангай, Баянхонгор, Баян-Өлгий, Дархан, Ховд, Хэнтий, Өмнөговь аймгийн засаг дарга нар МАН-ын хурал цуглаануудад оролцож байсан бол, Улаанбаатар хотод болсон МАН-ын цуглааны үеэр Батлан хамгаалах яамны сайд олон нийтэд хандаж үг хэлсэн байна.

Сонгуулийн сурталчилгааны үеэр нийгмийн сүлжээ чухал үүрэг гүйцэтгэж байна. Бүх нэр дэвшигч өөрийн нүүр ном буюу Facebook хуудастай, МАН болон АН-ын нэр дэвшигчид жиргээ буюу Twitter ашиглаж байгаагаас гадна сонгуулийн сурталчилгааны үйл ажиллагаагаа сурталчлах хувийн цахим хуудастай байна. Түүнчлэн нэр дэвшигчид олон нийтэд хандсан сурталчилгаагаа нэмэгдүүлэх үүднээс Facebook-ийн шууд дамжуулалтыг ашиглаж байна. Нийгмийн сүлжээг сонгуулийн луйврын талаар сэжиглэж буй мэдээллээ тараах, мөн сонгуулийн үйл явц шударга явагдаж буйд эргэлзээ төрүүлэхэд өргөн ашиглаж байна¹³.

IX. СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААНЫ ЗАРДАЛ

Сонгуулийн сурталчилгааг хандиваар болон нэр дэвшигчдийн хувийн хөрөнгөөр санхүүжүүлж байна. СТХ-иар иргэний хувьд 3 хүртэл сая төгрөг (1,100 евро), хуулийн этгээдийн хувьд 15 хүртэл сая төгрөг (5,500 евро) байхаар хязгаарлажээ. Бэлэн мөнгөөр өгч буй бүх хандив нь тодорхой банкны дансаар дамжуулан хийгдэх ёстой бол, мөнгөн бус хандивыг зардлын хязгаараар тогтооно.¹⁴ Тодорхой нэр хаяггүйгээр хандив өгөх, хүлээн авахыг хориглоно.

Нэр дэвшигчдэд өрсөлдөх боломж, нөхцлийг ижил тэгш байлгахын тулд УАГ нь сонгуулийн сурталчилгааны зардлын хязгаарыг нэр дэвшүүлж буй намын хувьд 6.8 тэрбум төгрөг (2.5 сая евро), нэр дэвшигчийн хувьд 3.9 тэрбум төгрөг (1.5 сая евро) байхаар тогтоожээ. Сонгуулийн сурталчилгааны үеэр санхүүгийн бүх гүйлгээ нь тодорхой банкны дансаар дамжуулан хийгдэх ёстой. Бүх нэр дэвшигч сонгуулийн сурталчилгаа эхлэхэд ийм данс нээлгэжээ. АН болон МАХН-аас нэр дэвшигчид хандив цуглуулахдаа нийгмийн сүлжээ ашигласан бол, МАН хандив цуглуулах сурталчилгаагаа сонины хэвлэлд нийтэлжээ. Түүнчлэн МАХН-ын нэр дэвшигч Улаанбаатар хотын захуудаар явж, дэмжигчдээсээ бэлэн мөнгөний хандив гуйсан байна.

Сонгуулийн сурталчилгааны зардлын тайланг сонгууль дууссаны дараа тайлагнахаас өөр шаардлагыг хуульд заагаагүй байна. Сонгуулийн сурталчилгааны зардалтай холбогдох заалтуудыг зөрчсөн тохиолдолд оногдуулах торгууль нь харьцангуй бага байгаа боловч үйлдвэрчний эвлэл, шашны болон төрийн бус байгууллагууд, гадаадын хуулийн этгээдүүд зэрэг хандив өгөхийг хориглосон этгээдээс хандив авсан бол тухайн нэр дэвшигчийг нэрийн жагсаалтаас хасах зохицуулалттай.

X. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсад 458 хэвлэл мэдээллийн хэрэгсэл үйл ажиллагаа явуулж байна. Хэвлэл мэдээллийн байгууллагын өмчлөл бүрхэг, мэдээллийн агуулга нь улс төрийн харьяаллаар тодорхойлогдож байна. Зар сурталчилгааны зах зээл нь хязгаарлагдмал, мөн засгийн газар

¹³ Нийгмийн сүлжээнд их шуугиан тарьж буй мэдээлэл нь МАН-ын удирдлагууд төрийн албыг наймаалцаж, ашиг олох гэж байна гэх нууц бичлэг задарсан тухай байв. АН энэ талаар 5-р сарын 31-ний өдөр УИХ-ын тусгай нээлттэй хэлэлцүүлэг өрнүүлсэн. Түүнчлэн нийгмийн сүлжээг санал тоолох автомат машины үнэн зөвд эргэлзэх уур амьсгал бүрдүүлэх нэг талбар болгон ашиглаж байна.

¹⁴ СТХ-д зааснаар мөнгөн бус хандивын үнэлгээг хоёр талын хооронд байгуулах хандивын гэрээгээр харилцан тогтоож байгаа нь сонгуулийн зардлын хэмжээг хуурамчаар гаргахад хүргэх боломжтой.

нийгмийн сурталчилгаанд зориулан хөрөнгө ихээр зарцуулж байгаа явдал нь хэвлэл мэдээллийн байгууллагуудыг олон нийтийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай сайн харилцаатай байхын тулд санал зөрөлдөөнтэй сэдвүүдээс зайлсхийхэд хүргэж байна. Мэдээлэл авах гол үүсвэр нь телевиз хэдий ч, Улаанбаатар хот болон хот суурин газруудад интернетийн хэрэглээ, ялангуяа олон нийтийн сүлжээ түгээмэл байна.

Монгол Улсын Үндсэн хуулиар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг баталгаажуулсан байдаг бөгөөд Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулиар (ХМЭЧТХ) хяналт тавихыг хориглодог. Хүний нэр төрд халдан гутаах нь эрүүгийн гэмт хэрэгт тооцогдох хэвээр байгаа ба хорих ялаар шийтгэх заалттай байдаг.¹⁵ Энэхүү хуулийн заалт нь 2017 оны 7-р сарын 1-ний өдрөөс эхлэн хүчингүй болж, иргэний хариуцлага хүлээх заалтаар солигдоно. Гэвч Зөрчлийн тухай хуульд заасан хүний нэр төр гутаах, гүтгэх, худал мэдээлэл тараах зэрэгт оногдуулсан торгуулийн хэмжээ нь өндөр байгаа учраас зарим радио телевиз, сонин хэвлэл болон цахим мэдээллийн хэрэгслүүд нэвтрүүлэг, нийтлэлээ нэг бүтэн өдрийн турш буюу 4-р сарын 27-ны өдөр түр зогсоов. УИХ-аар торгуулийн хэмжээг багасгаж өгсөн ч, ЕАБХАБ/АИХЭГ-ны САХХ-тай уулзаж ярилцсан хүмүүс ийм шийтгэл нь хэвлэл мэдээллийн байгууллагууд өөрсдөдөө хяналт тавихад хүргэнэ хэмээн санаа зовж байна.¹⁶

СТХ-иар олон нийтийн болон хувийн хэвшлийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд нь нэр дэвшигчдийн талаар мэдээлэл хүргэхдээ үл ялгаварлан, үнэн шударгаар мэдээлэх үүрэгтэй. Эдгээр хориглосон заалтыг хууль эрх зүйн хүрээнд бүрхэг тодорхойлж өгчээ.¹⁷ Цаашилбал СТХ-иар мэдээллийн хөтөлбөрт гаргах нэр дэвшигчдийн мэдээг нэг өдөрт таван минут байхаар хязгаарлаж өгсөн ба өрсөлдөгчдөд мэдээний нэвтрүүлэгт орон зай худалдахыг хориглосон байна. Монголын үндэсний олон нийтийн радио телевиз (МҮОНРТ) нэр дэвшигч тус бүрт өдөр бүр 15 минутыг оргил цагийн үеэр, мөн 2 минутыг мэдээний хөтөлбөрийн үеэр үнэ төлбөргүй нэвтрүүлэхээр хуваарилсан. Хувийн радио телевизүүд өдөр бүр цацагдах төлбөртэй улс төрийн сурталчилгааны 15 хүртэлх минутын нэвтрүүлгийг нэр дэвшигч бүрт худалдаалж болох ба үнэ нь ижил байх ёстой. 6-р сарын 5-ны байдлаар улсын болон нийслэлийн хэмжээнд нэвтрүүлгээ цацдаг 62, аймаг орон нутгийн хэмжээнд цацдаг 94 радио телевиз нэр дэвшигчидтэй гэрээ байгуулсан ба СЕХ болон СДСХ-дод тус тус хүргүүлэв.

Хэвлэл мэдээллийн байгууллагууд хууль тогтоомжийг хэрхэн биелүүлж байгаад Харилцаа холбооны зохицуулах хороо (ХХЗХ) болон Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар (ШӨХТГ) хяналт тавьж байна. СЕХ-ноос хэвлэл мэдээлэлтэй холбоотой өргөдөл гомдлыг шийдвэрлэх хэвлэл мэдээллийн тусгай зөвлөлийг байгуулах ёстой ч эдгээр өргөдөл, гомдлыг ХХЗХ болон ШӨХТГ-т хүргүүлэх боломжтой. ШӨХТГ-аас ЕАБХАБ/АИХЭГ-ны САХХ-нд мэдээлснээр ШӨХТГ нь бүх хэвлэл мэдээллийн хэрэгслийн мэдээллийн агуулгад СТХ-ийг хэрхэн дагаж мөрдөж байгаад хяналт тавих бол, ХХЗХ нь төлбөртэй сонгуулийн сурталчилгаа болон төлбөргүй нэвтрүүлэх нэвтрүүлгийн цагийн хуваарилалт дээр мониторинг хийнэ.

¹⁵ Одоогийн байдлаар хүний нэр төрийг гутаах нь хуулийн дагуу 36 сая төгрөг (13,370 евро) хүртэлх торгуультай, эсвэл 6 сар хүртэлх хорих ял ногдуулах бөгөөд хэрэв энэ нь онц хүнд хэрэгт тооцогдвол уг хугацаа нь тав хүртэлх жилээр сунгагдаж болно.

¹⁶ 2017 оны 5-р сарын 11-ний өдөр УИХ-ын санал асуулгаар хүний нэр төр гутаах, гүтгэх зэрэгт оногдуулсан торгуулийн хэмжээг аж ахуй нэгжид 100 сая төгрөгөөс 10 сая төгрөг (37,150 еврогоос - 3,715 евро) болон хувь хүнд 10 сая төгрөгөөс 1 сая төгрөг (3,715 еврогоос - 372 евро) болгон бууруулан тогтоов.

¹⁷ СТХ, Эрүүгийн хууль, Иргэний хууль, Захиргааны хариуцлагын тухай хууль, Зөрчлийн тухай хууль болон бусад хуулиудад бүгд хүний нэр төр гутаах, гүтгэх, худал мэдээлэл тараах тухай тодорхойлсон заалтууд оруулжээ.

ШӨХТГ нь зөвхөн сануулга өгөх эрхтэй бөгөөд хэрэв зөрчил давтагдсан тохиолдолд зохих шийтгэл оногдуулахаар ХХЗХ-т хандаж болно. 6-р сарын 6-ны байдлаар ШӨХТГ-аас таван телевиз, есөн цахим хуудаст сануулга өгсөн байна.

ЕАБХАБ/АИХЭГ-ны САХХ нь 5-р сарын 29-ний өдөр хэвлэл мэдээлэлд хийх тоон болон чанарын мониторингийг эхлүүлсэн.¹⁸ Сонгуулийн сурталчилгаа эхлэхээс өмнө цаг үеийн мэдээ, үйл явдлын хөтөлбөрөөр сонгуульд нэр дэвшигчдийг өргөнөөр гаргаж, радио телевизийн мэдээний нэвтрүүлэгүүдэд төлбөртэй агуулга бүхий сурталчилгаа орсон нь ажиглагдав.

XI. ӨРГӨДӨЛ ГОМДОЛ

Иргэн, хуулийн этгээд нь сонгуулийн үйл явцад хамаарах аливаа шийдвэр, үйл ажиллагааны талаар өргөдөл гомдол гаргах эрхтэй байдаг. Сонгуулийн хороодын үйл ажиллагаа (үйлдэл, эс үйлдэхүй)-ны улмаас эрх нь зөрчигдсэн гэж үзвэл өргөдлөө эхлээд тухайн сонгуулийн хороонд гаргасан байх ёстой. Гаргасан шийдвэр нь, эсвэл ямарваа шийдвэр гаргаагүй гэж үзвэл дээд шатны хороонд давж заалдах боломжтой. СЕХ-ны шийдвэрийг эхлээд Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд анхан шатны журмаар гаргах ба цаашлаад Дээд шүүхэд хандана. Үндсэн хуулийн цэц нь СЕХ-оос гарч буй шийдвэрүүд Үндсэн хуультай нийцэж байгаа эсэхэд маргаан үүсгэдэг. Сонгуулийн хороод болон шүүхийн байгууллагуудын хооронд зарим нэг давхацсан хууль эрх зүйн зохицуулалт харагдаж байна. Сонгуулийн сурталчилгаатай холбоотой зөрчлүүдийг оролцуулан захиргааны ба эрүүгийн хэргүүдийг эхлээд цагдаагийн газраас шалгаж тогтоогоод, доод шатны шүүхээр хянан шалгуулдаг.

Маргааныг шийдвэрлэх эцсийн хугацаа нь сонгууль дууссаны хойно хүртэл сунжрахад хүргэж байна.¹⁹ Нэхэмжлэл гаргагч нь сонгуулийн байгууллагын маргаантай шийдвэр гарсан өдрөөс хойш 10 хоногийн дотор нэхэмжлэл гаргах эрхтэй. Захиргааны хэргийн шүүх 40 хоногийн хугацаанд сонгуультай холбоотой хэргүүдийг шийдвэрлэх ба Дээд шүүх нь 21 хоногийн хугацаанд давж заалдсан хэрэг дээр шийдвэр гаргана. Үндсэн хуулийн цэцэд шийдвэр гаргах талаар тодорхой заасан хуулийн эцсийн хугацаа байдаггүй.

МАХН-аас нэр дэвшигчийг сонгуульд нэр дэвшигчид тавигдах шаардлагыг хангаагүй гэсэн үндэслэлээр бүртгэхээс татгалзсан СЕХ-ны шийдвэрийг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд хандан гомдол гаргав. Шүүх хуралдааныг эхлээд 6-р сарын 9-ний өдөр хийхээр товлов. ЕАБХАБ/АИХЭГ САХХ-нд мэдээлснээр доод шатны сонгуулийн хороодын бүрэлдэхүүнд хамаарах хоёр гомдол гарсан талаар мэдээлсэн ч, хараахан шийдвэрлэгдээгүй байна.

¹⁸ Мониторинг хийгдсэн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд нь олон нийтийн радио телевиз (МҮОНРТ), арилжааны телевизийн дөрвөн суваг (Ийгл ньос, Монгол HD, ТВ5, ТВ9) болон хувийн хэвшлийн таван сонин (Өдрийн сонин, Өнөөдөр, Зууны мэдээ, Засгийн газрын мэдээ) болно.

¹⁹ Жишээлбэл, СЕХ-оос 2016 оны УИХ-ын сонгуульд МАХН-аас нэр дэвшигч тус намын даргыг нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзсан шийдвэр нь бүр 2016 оны 11-р сарын сүүлээр шийдвэрлэгдсэн.

ХII. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ОРОЛЦОО

Хууль эрх зүйн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төрд оролцох эрхийг хүлээн зөвшөөрч, улс төрийн намуудад сурталчилгааны материалаа тэдэнд хүртээмжтэй болгох, мөн хөгжлийн бэрхшээлтэй нэр дэвшигчдэд дэмжлэг үзүүлэх зэрэг үүргийг заажээ.²⁰ СТХ-иар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн санал өгөх эрхээ эдлэх боломжийг хөнгөвчлөн, санал авах байр нь тэргэнцэртэй сонгогчдод орох нөхцөл боломжоор хангагдсан байх, харааны бэрхшээлтэй сонгогч уншиж болохуйц санал өгөх зааварчилгаа байлгах, санал өгөхөд тохиромжтой бүхээг зэргээр тоноглогдсон байхыг заажээ. СЕХ нь эдгээр шаардлагыг ханган биелүүлсэн боловч хөдөө орон нутгийн дэд бүтцийн нь санал авах байруудад орох боломж нөхцлийг хязгаарлах магадлалтай байна. Мөн хөгжлийн бэрхшээлтэй сонгогчид нь оршин суугаа хаягаараа зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгөх хүсэлт гаргах боломжтой.

СЕХ-ноос харааны бэрхшээлтэй иргэдэд зориулан сонгогчдын боловсролд зориулсан материалыг бэлтгэн, дохионы хэлийг сонгогчдын боловсролд зориулсан видео бичлэгтээ нэмж оруулжээ. Түүнчлэн хэд хэдэн иргэний нийгмийн байгууллага (ИНБ) гол төлөв СЕХ-той хамтран хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд сонгогчдын боловсрол олгож байна. АН болон МАН-аас дэвшиж буй нэр дэвшигчдийн хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах, амьдралын чанарыг сайжруулах заалтуудыг агуулжээ. Гэсэн хэдий ч ИНБ-ууд улс төрийн намуудыг өөрсдийн нэр дэвшигчдийн талаарх мэдээллийг харааны болон сонсголын бэрхшээлтэй сонгогчдод зориулан хүргэх тал дээр хүчин чармайлт гаргах эсэхэд нь санаа зовниж буйгаа илэрхийлэв.

ХIII. ИРГЭНИЙ БА ОЛОН УЛСЫН АЖИГЛАГЧИД

Сонгуулийн ажиглагч томилох эрхийг дотоод, гадаадын ба олон улсын байгууллагуудад, мөн нэр дэвшигчээ дэвшүүлж буй намуудад олгож байна. Иргэд олон нийтийн ажиглагчид нь эхлээд СЕХ-ноос итгэмжлэгдсэн байх шаардлагатай бол, сонгуулийн хэсгийн хороод дээр ажиглагч хийх иргэд нь тухайн санал авах хэсгийн хороондоо сонгууль болохоос дор хаяж гурав хоногийн өмнө өргөдлөө гаргасан байх ёстой. СЕХ нь одоогийн байдлаар хэвлэл мэдээлэл, сонгуулийн сурталчилгааны зардал болон санал тоолох электрон төхөөрөмжийн бэлтгэл ажилд мониторинг хийн ажиллаж буй зургаан байгууллагын сүлжээ болох “Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт сүлжээ”-г итгэмжлэн үнэмлэх олгожээ.²¹ Энэхүү сүлжээ нь СЕХ-той тус төхөөрөмжид нэмэлт шалгалт хийхээр ойр хамтран ажиллаж байна. Нийслэлээс гадна байрлаж буй цөөн тооны ИНБ сонгуультай холбоотой үйл ажиллагаа, ажиглалт хийх зэрэгт идэвхтэй оролцож байна. Нэр дэвшигчээ томилсон намууд сонгуулийн өдөр ажиглагч ажиллуулахаар төлөвлөж байна.

Ажиглагчдын эдлэх эрх нь дуу болон дүрс бичлэгийн хэрэгсэл ашиглан сонгуулийн үйл явцыг баримтжуулах, зөрчил гарвал СХХ-нд мэдэгдэж залруулахыг хүсэх, сонгуулийн байгууллагын

²⁰ 2016 оны Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль

²¹ Сүлжээний гишүүн байгууллагууд нь: Нээлттэй нийгэм форум, Глоб интернэшнл, МИДАС, Өөрчлөлтийн төлөөх Эмэгтэйчүүд ТББ, Захиргааны шинэ санаачлаг болон Бодлогод залуусын хяналт ТББ-аас бүрдэж байна.

бүх төвшинд өргөдөл гомдолтой холбогдох мэдээлэл авах, ажиглалтын тайлангаа хэвлэн нийтлэх болон саналын хуудасны зурган ба тоон үзүүлэлтийг цахим хэлбэрээр хуулбарлан авах гэх зэргээр өргөн хүрээтэй тусгагджээ.

XIV. ЕАБХАБ/АИХЭГ-НЫ САХХ-НЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

ЕАБХАБ/АИХЭГ-ны САХХ нь 2017 оны 5-р сарын 22-ны өдөр Монгол Улсад үйл ажиллагаагаа эхлүүлэв. ЕАБХАБ/АИХЭГ-ны САХХ нь Гадаад харилцааны яам, СЕХ, төрийн байгууллагууд, түүнчлэн улс төрийн намууд, хэвлэл мэдээлэл, иргэний нийгэм болон олон улсын нийгэмлэгийн төлөөллүүдтэй уулзалт хийв. Мөн САХХ-ны тэргүүн Архангай аймагт айлчлан, орон нутгийн засаг захиргаа, сонгуулийн байгууллагын болон аймаг орон нутгийн намын хороодын удирдлагууд, иргэний нийгмийн төлөөллүүдтэй уулзав. Олон улсын урт хугацааны 20 ажиглагч холбогдох сургалт зааварчилгаа авч, 5-р сарын 30-наас эхлэн хөдөө орон нутагт байршин, орон нутгийн төвшинд сонгуулийн оролцогч талуудтай холбоо тогтоон, ажиглалтаа хийж байна. ЕАБХАБ/АИХЭГ-ны САХХ нь сонгуулийн өдрийг ажиглуулахаар өөрсдийн төлөөллийг ирүүлэх ЕАБХАБ-ын Парламентын Ассамблей болон Европын Парламенттай хамтран ажиллах болно.

*Энэхүү тайлангийн Англи хэл дээрх хувилбар нь албан ёсны хувь болно.
Монгол хэл дээрх албан бус орчуулгыг авах боломжтой.*